НАРАН СУМЫН 2023 ОНЫ 4-Р САРЫН
НЭГДСЭН ТАЙЛАН

2023.05.25 № 05 Хонгор

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

“ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд улиас 800, хайлаас 500, үхрийн нүд 30, монос 90 нийт 1410 ш модыг суманд авчиран албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хямдралтай үнээр зарж, “Тэр бум мод” хөдөлгөөнд нэгдэж хүн бүр байгаль хамгаалагч байхыг уриалж, бүх нийтээр мод тарих ажил амжилттай явагдаж байна.

2023 оны 5 сарын 25-ны 10:00 цагт Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтайн Ганибал нар Монгол Улсын Үндсэн Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа цаг үеийн асуудлаар иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт хийлээ.

Нийтийг хамарсан ажил (сэг зэм устгал, булгийн эх сэргээн засварлах, хог цэвэрлэх) мод тарих ажилд нийт 22 хүн ажиллаж байна.

Иргэдэд цаг агаарын нөхцөл байдлаас урьдчилан, сэргийлж малаа хариулгатай байлгах шаардлагагүй тохиолдолд холын замд гарахгүй байх өөрсдийн аюулгүй байдлыг болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангаж хөдөлгөөнд оролцохыг анхааруулж ажилласан.

Өлзиит булгийн үхсэн мал зэмийг ойр орчмын айлууд зөөж, цэвэрлэсэн.

Засаг даргын мөрийн хөтөлбөрөөс 5000000/таван сая/ төгрөгөөр санхүүжүүлэн жил бүр зохион байгуулагддаг “Явуулын амбулатор”-ын үзлэг Наран ЭМТ-д 2023 оны 05 сарын 09-11-ний өдрүүдэд;

- Дотор
- Эмэгтэйчүүд
- Хүүхэд
- Мэдрэл
- Гэмтэл
- Нүд
- Чих хамар хоолой
- Рентген
- Хэвлийн эхо чиглэлээр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийгдэж, иргэд идэвхитэй хамрагдлаа.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Ө.Тайвансанаа, сумын Засаг дарга Л.Оч нарын урилгаар Төрийн соёрхолт Яруу найрагч О.Дашбалбар агсны эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйлсээр “Наранбулгийн хүү” үзэсгэлэнг 5 сарын 04, 05-ны өдрүүдэд Соёлын төвд зохион байгуулж, үзэсгэлэнгийн нээлт 5 сарын 04-ны өдрийн 14 цагаас Соёлын төвд болж, иргэд хөдөлмөрчид өргөнөөр оролцлоо.



<u>УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧИГ:</u>

2023 оны 05-р сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-05-р сарын байдлаар дээд газраас нийт 39 албан бичиг ирснээс, хариутай бичиг 11 ирж, 8 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 3 албан бичиг байна.

-Мөн 05 сарын байдлаар нийт 2 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 1, Аймгийн Засаг даргын Албан даалгавар- 1 ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

<u>Дотоодын ажлын талаар:</u>

2023 оны 05-р сарын байдлаар;

1.Сумын Засаг даргын А-Захирамж - 8

2.Сумын Засаг даргын Б-Захирамж – 3

3. Албан даалгавар – 0

4.Засаг даргын албан бичиг -1

5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 3

6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 7

7.ЗДТГ-ын даргын албан бичиг -4

Нийт 10 албан бичгийг цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхлээд байна.



Засаг даргын Тамгын газар, ИТХ, Соёлын төвийн албан хаагчдад 5 сарын 1-нээс эхлэн Монгол бичгийн багшаар үндэсний бичгийн сургалтыг явуулж эхэллээ.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдыг мэдээ мэдээллээр хангах мал аж ахуйн бодлого шийдвэр болон шинэ технологи сурталчилах өнөөгийн бодит байдлыг хэлэлцэх шийдвэрлэх зорилгоор зохион байгуулсан “МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН-2023” арга хэмжээ тусгай хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулагдлаа.


ХӨТӨЛБӨР

2023.05.03-ны 14 цагт

- СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ /Гар бөмбөг, буухиа, олс таталт

2023.05.04-ны 10 цагт

- МАЛЧИН ЗАЛУУЧУУДЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН / жич: цолгүй бөх барилдана/

2023.05.05-ны 10 цагт

- “МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН”
- О.ДАШБАЛБАРЫН МУЗЕЙН ҮЗЭСГЭЛЭН
- СУМЫН НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА
- ҮДШИЙН ЦЭНГҮҮН /хүндэтгэлийн хуледэн авалт /

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:
НАРАН СУМЫН ЗДТГ-ХХААТ
1-Р БАГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ НАР,
БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАР

Зөвлөгөөн 2023.05.03-ны өдөр малчдын дунд зохион байгуулагдсан спортын арга хэмжээгээр эхэлсэн бөгөөд тус тэмцээнд 8 багийн 93 хүн хамрагдаж оролцсон бөгөөд М.Ганхөлөг ахлагчтай “Жавхлант-Улз” баг 1-р байр, Ө.Боргил ахлагчтай “Наранбулаг” баг 2-р байр, Ш.Бямбаноров ахлагчтай “Өлзийт” баг 3-р байрыг тус тус эзэллээ. Мөн ширээний теннис, дардасны тэмцээн зохион байгуулагдсан.

2023.05.05-ны зөвлөгөөнд Аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч Ө.Тайвансанаа , Хөдөө аж ахуйн газрын дарга, мэргэжилтэн, мал эмнэлгийн эрүүл147 малчин мал бүхий иргэд хамрагдаж хөдөө аж ахуйн одоогийн нөхцөл байдал болоод салбарын сүүлийн үеийн мэдээ мэдээллийг авч ажилласан . Үүнд:

- Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газрын дарга –Т.Ган-Очир малын чанарыг сайжруулах үхэр сүрэг дээр ямар үүлдэрийн бухыг сайжруулагчаар ашиглах , хөдөө аж ахуйн салбарын хөгжил дэвшил дэлхийн чиг хандлагын талаар мэдээлэл

- Аймгийн мал үржлийн албаны дарга –Б.Мөнхбаяр малын үржүүлэг болоод авах арга хэмжээ , эрчимжсэн аж ахуй, бэлчээрийн талаар мэдээлэл
- Аймгийн мал эмнэлгийн газрын эрүүл мэндийн албаны дарга –Ж.Сундуй малын эрүүл мэндийн талаар мэдээлэл
- Хилийн цэргийн 0184-р ангийн бие бүрэлдэхүүн хилийн албаны тухай хууль тогтоомж дүрэм журамын талаар
- Сумын засаг дарга үйл ажиллагааны тайлан цаашид хийх ажлын мэдээлэл тус тус өгч ажилласан.

Тус зөвлөгөөнөөр мал аж ахуйн салбарт амжилт бүтээл гаргасан малчдад салбарын болоод аймаг сумын шагналаар дараах иргэдийг шагнасан.

- Сүхбаатар аймгийн хүндэт иргэн-1-р багийн ахмад малчин Д.Будсүрэн
- Аймгийн ИТХ-ын хүндэт жуух бичгээр- 1-р багийн малын эмч Ц.Энхмаа
- Аймгийн ИТХ-ын хүндэт жуух бичгээр -1-р багийн ахмад настан М.Борчулуун
- Аймгийн ИТХ-ын баярын бичгээр -1-р багийн ахмад малчин Т.Борчулуун
- Аймгийн ИТХ-ын баярын бичгээр -2-р багийн малчин Ж.Ганбаатар
- Аймгийн Засаг даргын баярын бичгээр -2-р багийн малчин Б.Батболд
- Аймгийн Засаг даргын жуух бичгээр- 2-р багийн малчин Ц.Ариунтуяа
- Аймгийн Засаг даргын жуух бичгээр – Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч Г.Сугар
- Сумын аварга хадланчаар -3-р багийн иргэн Х.Пүрэв-Очир

Зөвлөгөөнөөр малчид иргэд дараах санал шүүмжлэлийг гаргасан. Үүнд: 1-р багийн малчин М.Сумъяажав- Нөөцийн өвс тэжээлийг жигд хүртээмжтэй олгомоор байна. Хадлан бэлтгэж байгаа хүмүүст бензин түлшны хөнгөлөл үзүүлж баймаар байна.

Ч.Дашням:Бэлчээрийн мэрэгч устгамаар байна . Оготно устгалыг яаж хийх вэ ?

М.Отгон: Малчид малын тоо толгойн албан татвараа төлснөөр нөөцийн өвс бэлтгэх ажил амжилттай хэрэгждэг. Үүнийг би дотор нь ажиллаж байсан хүний хувьд хэлэх байна. Манай малчид МИД-д малаа хэр хамруулдаг вэ ? Хамрагдалтын хувь гэж гардаг уу? Энэ талаар малчдад мэдээлэл хэрэгтэй байна. Мөн хогны асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол хогны асуудал манай суманд хүндрэлтэй асуудлын нэг байна. Гэх мэт асуулт санал хүсэлт гарч тухайн асуудалд сумын засаг дарга, ХХААГ-ын дарга , ХАА-н мэргэжилтэн нар хариулт өгч ажиллаа.

Зөвлөгөөний үйл ажиллагааг дэмжиж хувиараа хөдөлмөр эрхлэгч Б.Сарантуяа, Наран сумын хүүхдийн цэцэрлэгийн хамт олон хүүхдийн хоолны амталгааг зохион байгуулж нийт 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээр малчдад үйлчиллээ.

Нийт малчдыг сумын соёлын төвийн хамт олон болон ИТХ-тай хамтран босоо хүлээн авалт буюу үдшийн цэнгүүн зохион байгуулсан бөгөөд тус үйл ажиллагаанд нийт 220 гаруй малчин оролцлоо. Тус үйл ажиллагааны үеэр сугалаа зохион байгуулсан бөгөөд нийт ... сугалаа явагдаж 50 иргэн азтан боллоо.

2023.05.07 нд Малчдын зөвлөгөөн-2023 арга хэмжээнд зориулсан цолгүй залуу бөхчүүдийн барилдаан зохион байгуулж барилдаан 20 залуу бөх барилдаж залуу бөх Ц.Ганцоож түрүүлж , залуу бөх Ц.Банзрагч үзүүрлэлээ.

Малчдын зөвлөгөөн 2023 арга хэмжээг зохион байгуулахад ОНХС-аас 3 сая төгрөг Засаг даргын нөөц сангаас 1,3 сая төгрөгийн зарцуулсан ба зардалыг задалж үзвэл малчдын зөвлөгөөнд зориулсан бичиг хэргийн зардалд 462850 төгрөг, ХХААГ-ын дарга мэргэжилтэн авчирсан замын зардалд 262500 бөхийн барилдааны шагналд 300,000 төгрөг, сугалаанд 1200000 төгрөг, хүлээн авалтанд 2037150 төгрөгийн зардал гаргасан байна.

САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- **Төрийн сан:** Төсөвт байгууллагуудын 5 сарын цалинтай холбоотой болон цалингаас бусад өдөр тутмын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн түргэн шуурхай цахимаар хянаж байна. 2022 оны 05 сарын 1-ээс 05 сарын 24-ны хооронд төсөвт байгууллагын 52 гүйлгээг хийж гүйцэтгэсэн.

ЗДТГазрын даргын баталгаажуулах албан тушаалтны гүйлгээ батлах гар утасны Authy болон Free OTP программыг шинээр татаж гүйлгээ батлах 1 удаагийн нууц үг тохируулсан.





5 сарын аж үйлдвэрийн 4 мэдээг хугацаанд нь sukhbaatar.nso.mn хаяг руу хүргүүлсэн.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэний 1972500 төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн.

Шинэ ажлын байр -19,Ажил зуучлалаар -19 ejob программд бүртгэсэн.

Төсөл хөтөлбөрт хамрагдсан 3 иргэнтэй гэрээ хийн холбогдох материалыг ХХҮГ-т хүргүүлсэн.

Малжуулах хөтөлбөрт хамрагдах 5 малчинд хөтөлбөрийн талаар танилцуулан материалыг бүрдүүлэн ХХҮГ-т хүргүүлсэн.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөтөлбөр 05 сарын 05-ны өдрөөс эхлэн монгол бичгээр зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Аж ахуй эрхлэлтийн сургалтанд 6 иргэнийг хамруулсан.

Хүнд машин механизмын сургалтанд 3 иргэнийг бүртгэсэн.

Зохион байгуулалттай ажлын байрны арьс элдэх халимлах машиныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэнд хүлээлгэн өглөө.



05 дугаар сарын 23-нд “Сэг зэм устгал,булгийн эхийг сэргээн засварлах,цэвэрлэх”нийтийг хамарсан ажил,”Мод тарих” ажил эхлүүлж ажиллах иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж ажиллах,цаг барих цалин хөлстэй холбоотой мэдээлэл хийн гарын авлага тараан бээлий маскыг олгосон.Засаг дарга иргэдэд хийгдэх ажил ,хариуцлагатай цаг барьж ажиллах талаар мэдээлэл өгсөн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр: 05 сарын 1-нд Засаг даргын тамгын газрын 15 ажилтанд ХАБЭА-н хууль,Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт хийн ХАБЭА ажилд хяналт хийлээ.

Байгууллагуудын ХАБЭА-н ажилд хяналт шалгалтыг хийж заавар чиглэл өгч ажилласан.



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛД ХЯНАЛТ ТАВЬСАН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Ерөнхий боловсролын сургууль	Нархан цэцэрлэг	Эрүүл мэндийн төв	Соёлын төв	Засаг даргын тамгын газар	"Мөлцөг Э ирэг"ОНӨААТҮГ
1	ХАБЭА-н төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө		Төлөвлөгөө	Хийгдсэн
2	ХАБЭА-н ажилтан томилсон тушаал		2021	2021.01.1	10	2021.01.1	+
3	Ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байдал	2022 8-ны 12 нд	2022.03	2021.11 сард хамруулсан	2022.04 сард	-	—
4	Галын аюулгүй байдлыг хангах	+	+	+	+	+	+
5	Байгууллагын ажилтнуудын алжаал тайлах ерөг бий болгох	+	Болгосон	Байхгүй.	—	+	—
6	Гал гогоонд агааржуулалтын систем/ өрөө стандартын дагуу бий болгосон байдал	Хөдөлгөөн	Агаарын чанарын стандарт хангасан	Сайн.			-
7	Ажилтнуудын албан ерөө гэрэлтүүлэг хангалттай түвшинд байгаа эсэх	+	Хангалттай +!	+	+	+	—
8	Хортой нөхцөлд ажиллах байгаа ажилтнуудад ажиллах нөхцөлийг сайжруулах,хамгаалах хувцас,хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангасан байдал зардуулсан хөрөнгө	-	338 000	1200 000 гэрэлтэгч, 10.500 гэрэл хий сорогч	-	3 000 000	1.680 000
9	Дотоод журмаа ажилтнуд хөдөлмөрийн нөхцөл сайжруулах талаар зөвлөгөө өгсөн эсэх	Зөвлөгөө өгсөн.	2021 12 сар	Байнга зөвлөгөө өгдөг	Байнга шинжлэх	Байнга.	—
10	ХАБЭА-н ажилтныг мэргэшүүлсэн байдал	1	2021.	1	1	1	Сурах ажил 0
11	ХАБЭА хариуцсан ажилтанд хувь нэмэгдэл олгохдоо хийсэн ажлыг дүгнэсэн эсэх	1	30%	40%	1	40%	0
12	ХАБЭА-н сарын аяны хүрээнд хийгдэж байгаа ажлын явц	1	Төлөвлөгөө 2021.01.03	Төлөвлөсөн сорилт.	1	Төлөвлөсөн сорилт хийсэн.	Төлөвлөгөөт
	НЭГТГЭЛ						

ХАБЭА-Н ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН ХЭЗААХМ Т.БОЛОРЧИМОГ ӨН.ПҮРЭВДОРЖ



04 сарын 29 –нд Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн үзлэгээр 63 жолоочид жолоочийн аюулгүй ажиллагааны зөвлөмж гарын авлагуудыг таралаж ажилласан.

5 дугаар сарын 1-нд ХАБЭА-н сарын аян,Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд эцэг эх- асран хамгаалагч-уралдаанч хүүхдийн “ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ" зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу сумын хамтарсан баг, сургуулийн захиргаа, ЭМТ, сумын ХАБЭАЗөвлөл хамтран зохион байгууллаа. 62 ээг эх,уяачид оролцсон.

- СНА-тан "Эцэг эх-асран хамгаалагч-уяачдын эрх үүрэг-уралдаанч хүүхдийн аюулгүй байдал" сэдвээр
- ЭМНА-тан "Уралдаанч хүүхдэд үзүүлэх анхны тусламж",”Хамгаалтын хувцасны стандарт” сэдвээр
- Эцэг эх, асран хамгаалагч, уяачдад аюулгүй байдлын гэрээг тус тус хийлээ.
- Соёлын төвийн дэргэдэх нарны хүүхдүүд бүжгийн дугуйлангийн хүүхдүүд мэндчилгээ дэвшүүллээ.
- Зөвлөгөөний дундуур уралдаанч хүүхдийг витамижуулах, хамтран зохион байгуулсан байгууллагууд, уяачид ивээн тэтгэж азын сугалаа явуулж, 20 хүүхдийг урамшууллаа.

- Гурван хонгор МСУХолбоо 180.0 төгрөний хамгаалалтын иж бүрэн хувцас-1ш
- ЭМТ-витамины багц-2ш
- ЕБС-хичээлийн хэрэглэлийн багц-2ш
-Наран ХАБЭА-н зөвлөл -сэтгэхүй хөгжүүлэх тоглоом 2ш багц
- Сумын засаг дарга-Л.Оч 50.0 төг
- 2-р багийн аймгийн алдарт уяач Г.Адарсүрэн хурдан удмын даага
- 2-р багийн сумын алдарт уяач Б.Азжаргал хурдан удмын даага
- 1-р багийн ЗД С.Сугар-30.000 төг
- 2-р багийн ЗДарга Ц.Төмөрсүх халуун хошуутай хонь
- 1-р баг аймгийн алдарт уяач У.Сүхболд 40.0 төг

5 дугаар сарын 2-нд ХАБЭА-н сарын аяны хаалтын үйл ажиллагаа болгон байгууллагын ажилчид иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх үүднээс сумын Засаг даргын нэрэмжит “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг ЗДТГ,ХАБЭА-н зөвлөл байгууллагуудын ХАБЭА-н ажилчид хамтран зохион байгууллаа.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА БАТЛАВ:
Э.ЗУЛЦЭЦЭГ
2023 оны сарын өдөр
Удирдамж

1. Зорилго: "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх" хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд ажилтан албан хаагчид,иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх,чөлөөт цагийг зөв болгосон өнгөрүүлэх
2. Зохиогдох тэмцээн: " Гар бөмбөгийн тэмцээн"холимог /3 эрэгтэй,3 эмэгтэй/
3. Хугацаа: 2023-05-02 ны өдрийн 13 цагт ЕБС-ийн спорт заалаанд
4. Хамрах хүрээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хувийн хэвшил иргэд
5. Багуудын тэмцээнд оролцох журам
- Жигд хувцастай байх, номертой байх
6. Шагнал: 1-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
2-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал

ЖИЧ. ЕБС-ийн хүүхэд орохгүй, шүүгчтэй зөв зохистой хөрөнгөтэй, жигд хувцаслах,шүүгчийн шийдвэрийг дагаж зохион байгуулалттай оролцоно.

"ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНЫ 2023

Зохион байгуулагч: Наран сумын ХАБЭА зөвлөл
Байгууллагын ХАБЭА ажилчид

Нийгмийн халамжийн чиглэлээр:Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж шинээр асаргаа тогтоолгох 1 иргэний асуудлыг хэлэлцсэн.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа явагдана .05 сарын 24-нд 4 өрхөөс судалгааг авахаар бэлтгэл ажлыг хангасан.

05 сарын 5-нд малчдын зөвлөгөөнд оролцож 122 хүнд 1464 ширхэг гарын авлагыг тараасан.

Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 5 дугаар сарын 30-ны байдлаар

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	148	42149264
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	162	14753191
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	69	12725239
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	80	6620000
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	43	840645
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	74	2599241
7	Алдарт эхийн одонтой эхэд	139	18100000
8	Хүүхэд асарсны тэтгэмжинд	452	22058435

<u>МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:</u>

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хийж

эхэлсэн. Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан дархлаажуулалтын явц удаашралтай явагдаж байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. СУРГАЛТ:

С.Энхжаргал багштай 2а ангийн хамт олондоо Сүхбаатар аймгийн бага боловсролын ЗӨВЛӨХ ЗЭРЭГ-тэй багш нарын зохион байгуулсан "Уншъя сэтгэе хөгжье" унших чадварыг дэмжих уралдаанд амжилттай оролцож ОЙЛГОН УНШИХ ЧАДВАР төрөлд 3-р байр, ХУРДАН УНШИХ ЧАДВАР-төрөлд тусгай байрыг тус тус эзэллээ.

2-р ангийн "Ойлгон унших чадвар"-ын төрөлд амжилттай оролцсон анги бүлэг

/16-н сургуулийн 47 бүлэг оролцсон/

2022-2023 оны хичээлийн жил

№	Сургууль	Анги бүлэг	Багшийн нэр	2022-11 Гүйцэтгэл	2022-12 Гүйцэтгэл	2023-03 Гүйцэтгэл	ДУНДАЖ	Унших хурдын дундаж	Байр
1	3-р сургууль	2б	О.Мөнхзул	90.7	78	91	86.57	51.7	I байр
2	3-р сургууль	2а	Ө.Мөнхцэцэг	79.5	78	86	80.83	40.6	II байр
3	4-р сургууль	2а	Б.Уранбилэг	89	77	70	75.67	55.3	II байр
4	4-р сургууль	2б	Ж.Алтангүүл	77	78.5	67.8	74.43	54.9	III байр
5	Нараан	2а	С.Энхжаргал	75.4	83.9	63.8	74.37	49.3	III байр
6	Мөнххаан	2а	Б. Наидинцэцэг	64	76.1	77	72.37	45.2	III байр
7	Эрдэнэцагаан	2б	Г.Оюунчимэг	74	74.2	62.4	70.20	52.9	Тусгай байр
8	Эрдэнэцагаан	2а	С.Жаргалмаа	68	80.3	60.2	69.50	43.8	Тусгай байр
9	Эрдэнэцагаан	2а	Ш.Наргүй	74	72	58.5	68.17	40.5	Тусгай байр
10	1-р сургууль	2г	Т.Ариунаа	64.5	90.6	49.8	67.70	48.7	Тусгай байр

Зөвлөх зэрэгтэй багш нарын МХБ

БАТЛАМЖ

УНШЪЯ, СЭТГЭЕ, ХОГЖЬЕ-2023

Нараан...бөб.мн... сургуулийн С.Энхжаргал..... багштай 2а ангийн хамт олонд

Сурагчдыг зөв, хурдан, ойлгон унших чадварыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан "УНШЪЯ-СЭТГЭЕ-ХӨГЖЬЕ" массыг уралдаанд ХУРДАН УНШИХ ЧАДВАРЫН төрөлд анги хамт олноороо манлайлан ТУСГАЙ байр эзэлсэнд талархаж БАТЛАМЖ олгов.

Ухаан далай номоос эхлэй

СҮХБААТАР АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР

БАГА БОЛОВСРОЛЫН "ЗӨВЛӨХ" ЗЭРЭГТЭЙ БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ

БАРУУН-УРТ 2023.04.06

"Сайн багшийн сайн технологи 2023" аймгийн багш нарын ур чадварын уралдаанд сургууль хамт олноо манлайлан НИЙГМИЙН УХААНЫ багшийн төрөлд багш Э.Оюунтунгалаг мэргэжлийн аргазүй, ур чадвараараа манлайлан 2-р байр, бага

ангийн багш Монхор овогтой Ганболор, математикийн багш Одгэрэл овогтой Мөнхзул нар тус тус амжилттай оролцлоо.

2023.05.04-ны өдөр ДЗАН-ээс зохион байгуулж байгаа "Funny lesson" хичээл үйл ажиллагааг мэргэжлийн багш сургалтын идэвхтэй аргыг хэрэглэн хосолсон сургалтын арга зүйгээр үнэлгээний олон аргачлалыг туршсан хичээлүүд зохион байгуулагдлаа.



Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд сургуулийн нэг өдрийн үйл ажиллагааг сурталчлан танилцуулах, тэдний санл бодлыг сонсож үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор өдөрлөгийг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Үүнд:

- Угталтын болон нээлтийн үйл ажиллагаа
- 2022-2023 оны хичээлийн жилийн хичээл сургалтын үйл ажиллагаа болон хүүхэд-хөгжил, оролцоо, хамгаалллын талаарх мэдээллийг сургалтын менежер, нийгмийн ажилтан нар цахим болон танхимын хэлбэрээр мэдээлэл хийж танилцуулан оролцогчдын санал бодлыг сонсож ажилласан.
- 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны эмчийн мэдээлэл
- БЗАН, Нийгмийн ухааны судлагдахууны баг, байгалийн ухааны судлагдахууны багуудын өртөөлчилсөн хөгжилтэй хичээлүүд хуваарийн дагуу явагдлаа.
- Үдийн хоол болон дотуур байрны суралцагчдын хоолны амтат зоогийн үзэсгэлэнг танилцуулж амталгаа хийлгэж, тэдний санал бодлыг сонсож ажилласан.

Байгууллагын болон багшийн гшйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалт, багшийн болон байгууллагын эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн орчны үнэлгээ хийх асуулгыг 2023.05.15-19-ны өдрүүдэд хуваарийн дагуу зохион байгууллаа.



2. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ:

"Эрүүл аюулгүй ажил- Бидний эх суурь" аяны хүрээнд дотуур байрны орчинд нөхцөлд сургуулийн удирдлагууд, дотуур байранд ажиллаж буй ажиллагсад анаахаралаа хандуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Үүнд:

Суралцагчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд үүдний 1-р давхарт нийт 4 ш сандалыг ажилчид хамтран нийт 240.000 төгрөгөөр хийлгүүлж орчин нөхцөлөө сайжруулаа. Мөн үүдний 1-р давхарт мэдээллийн самбар -2ш 150.000 төгрөгөөр хийлгүүлсэн. Дотуур байрны гадна үндэсний болон крил бичгийн хосолсон хаягийг 1.700.000 төгрөгөөр хийлгүүлэх ажлыг гүйцэтгэгч байгууллагад захиалан хийлгүүлж байна.

Аяны хүрээнд дотуур байрны сурагчид, ажилчдын уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж тэдний санал хүсэлтийг сонсох, тав тухтай аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор "ДОТУУР БАЙР - БИДНИЙ ГЭР" суралцагчдын зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу 2023.04.19-ны өдөр 19-22 цагийн хооронд зохион байгуулаа. Үүнд:

- ✓ Сургуулийн захирал нээж баяр хүргэж мэндчилгээ дэвшүүллээ.
- ✓ НА-тан "Хүүхдийн өөрийн удирдлага-хүүхдийн эрх үүрэг, дэг соёлын талаар
- ✓ Сургууль, дотуур байрны ажилчдад "Ажлын байранд баримтлах чиг үүрэг-тулгамдаж буй асуудал" сэдвээр
- ✓ Сургуулийн эмч "Цахим хэрэглээ-Донтолт"-оос урьдчилан сэргийлэх сэдвээр мэдээллийг тус тус хийж санал бодлыг сонсож ажилласан.

Дотуур байр, сургуулийн орчинд ажиллаж буй ажилчдаас ажлын байранд тулгамдаж буй асуудлын хүрээнд санал асуулгыг тус тус авч санал бодлыг нь сонсож ажилласан. Суралцагчдын **"Дотуур байр- бидний гэр"** уулзалт зөвлөгөөнийн санал асуулгыг дотуур

байранд амьдарч буй 37 суралцагчид, байгууллагад ажиллаж буй 14 ажилчдын хэрэгцээг тодорхойлох, санал хүсэлтийг сонсох зорилгоор авч дүгнэлт хийж сургуулийн удирдлагад уламжилж ажилласан.

"Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил", "Дотуур байр-Ээлтэй орчин" аяны хүрээнд дотуур байрын суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдын "ДОТУУР БАЙР-БИДНИЙ ГЭР" зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр:

- ✓ Сургуулийн захирал дотуур байрны орчин нөхцөл-цаашид хамтран ажиллах ажлын чиг үүрэг:
- ✓ СНА-тан эцэг эх, асран хамгаалагчийн эрх үүрэг -дотуур байрны хүүхэд хамгааллын бодлого, эрүүл аюулгүй байдал
- ✓ ЭМэндийн багш суралцагчдын эрүүл мэнд-шүдний өвчлөлийн талаар
- ✓ Дотуур байрны багш Дотуур байрны суралцагчдын дэг соёлын талаар:
- ✓ Тогооч нар хүнсний бүтээгдэхүүний хадгалах, орчин нөхцөл эрүүл ахуйг сайжруулах, дотуур байрны суралцагчдын 21 хоногийн хоолны цэсийг эцэг эх, олон нийтэд боршур бэлтгэн танилцуулах сургалт, мэдээллийг хийлээ. Мөн суралцагчдын 21 хоногийн хоолны цэсээр "Амтат зоог" барьж амталгаа хийлгэж, эцэг эх, асран хамгаалагчдын санал хүсэлтийг сонсож ажилласан.

Зөвлөгөөний төгсгөлд дотуур байрны орчин нөхцөл, ажиллагсдын харилцаа хандлага, цаашид анхаарах асуудлаар тэдний санал хүсэлтийг сонсож, сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн анхаарах асуудал, санал санаачлагыг сургуулийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жил болон хөдөлмөрийн аюулгүй байдал сарын аяны уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ" зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу сумын хамтарсан баг сургуулийн захиргаа, ЭМТ, сумын ХАБЭАЗөвлөл хамтран 2023.05.01-ны өдөр 14:30-15:00 цагийн хооронд зохион байгууллаа. Зөвлөгөөнд: Нийт уралдаанч 62 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, уяачид давхардсан тоогоор 44 хүн оролцлоо. Зөвлөгөөнд

- ✓ СНА-тан "Эцэг эх-асран хамгаалагч-уяачдын эрх үүрэг-уралдаанч хүүхдийн аюулгүй байдал" сэдвээр
- ✓ ЭМНА-тан "Уралдаанч хүүхдэд үзүүлэх анхны тусламж" сэдвээр
- ✓ Эцэг эх, асран хамгаалагч, уяач, уралдаанч хүүхдүүдийн санал хүсэлтийг сонсож, үүрэг хүлээгч нар хариулт өгөө.
- ✓ Эцэг эх, асран хамгаалагч, уяачдад “Аюулгүй байдлын гэрээ”, эцэг эх, асран хамгаалагчийн “Зөвшөөрлийн хуудас” -ийг тус тус хийж хүүхдийн аюулгүй байдылг хангаж ажилласан.
- ✓ Зөвлөгөөний дундуур уралдаанч хүүхдийг витамижуулах, хамтран зохион байгуулсан байгууллагууд, уяачид ивээн тэтгэж азын сугалаа явуулж, 20 хүүхдийг урамшууллаа.

"Сургууль (дотуур байр)-ийн хүүхэд хамгааллын эрсдэлт нөхцөл байдлын үнэлгээ"-г зохион байгуулсан үнэлгээний үр дүн, зөвлөмжийг танилцуулан сайжруулах цаашид авах арга хэмжээг оролцогч талууд ярилцаж, 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх, хамтын ажиллагааныхаа хүрээг тодорхойлох боломжийг бүрдүүлэх зорилгоор олон талт хэлэлцүүлэгийг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Үүнд:

- ✓ 2023.05.04-ны 14.30-аас 17.30 минутанд олон тал хэлэлцүүлгийг нийт 30 хүнийг оролцуулах зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үйл ажиллагааг нээж сургуулийн захирал Ө.Боргил, зохион байгуулагч СЭЭБХ-ны зохицуулагч Л.Болормаа нар баяр хүргэж эхлүүлсэн.

- ✓ Олон талт хэлэлцүүлгийн зорилго- оролцооны зарчмыг СНА-тан Д.Ариун-Эрдэнэ, Л.Болормаа нар танилцууллаа.
- ✓ 3 орчны Эрсдлийн үнэлгээний үр дүн, зөвлөмжийг багийн гишүүн бүр оролцогч талуудад танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонсож харилцан ярилцаж эсрдэл нэр бүр дээр хариулт авч ажилласан.

- ✓ 2023-2024 оны хичээлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахад эрсдлийн үнэлгээнээс гарсан асуудлуудыг эрэмблэж ирэх хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх саналыг сургуулийн удирдлагуудаас оролцогч талууд дараах хариултыг авлаа.

Багш солилцоо хөтөлбөрийн санхүүжилтээр сургуулийнхаа 2-р давхарыг “ЭКО КЛУБ”-ын орчин бүрдүүлж ажилласан.

2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн орсон суралцагчдын эрдмийн баярыг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж суралцагчид сурсан мэдсэн зүйлсээ эцэг эхчүүддээ тайлагналаа.

Хүүхэд хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд ЭМГ, ЭМТ, "Ортодонт " шүдний эмнэлгийн гурвалсан гэрээний дагуу Нүүр амны их эмч Д.Саруулбуян эмч ЕБС-ийн дотуур байрны хүүхдүүдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг хийж

- "Амны хөндийн эрүүл ахуй" сэдвээр эрүүл зан үйлийг төлөвшүүлэх арга, дадлын зөвлөгөө өгч, мэдээлэл хийлээ.

-Шүд эрүүл бол бие эрүүл уриалгад нэгдэж ЭМТ-өөс дархлаа дэмжин витаминжууллаа.

Сумын Засаг даргын 2023.05.04-ны өдрийн А\50 тоот захирамжаар 2023.05.07-ны өдөр сумын төв дээр зохион байгуулагдсан 4-н насны хурдан морины уралдаанд 2023.05.05 наас 2023.05.07-ны өдрүүдэд уралдааны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эцэг эх, асран хамгаалагч, уяачидтай хамтын гэрээ хийж, хамтарсан багаар уралдааны өдөр ажиллалаа.

5 сарын 4-ны оройн 20:00-21:00 цагт Дотуур байрны суралцагчдын дунд "Амны хөндийн эрүүл мэнд", "Шүдээ зөв угаах" сэдвээр сургалт явуулж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, цогт эх оронч, яруу найрагч Очирбатын Дашбалбар агсны эдлэл хэрэглэлээр Сүхбаатар аймгийн угсаатны зүйн музейн хамт олон 2023 оны 05-р сарын 4-6-ний хооронд Наран сумын Соёлын төвд “НАРАНБУЛГИЙН ХҮҮ” сэдэвт үзэсгэлэн нээлээ. 6-9-р ангийн сурагчид үзэсгэлэнг шимтэн үзэж, нутгийн бахархалт хүмүүний талаар өөрсдийн сонирхсон асуултаа асууж, олон сонирхолтой мэдээлэл, баримттай танилцан нэг өдрийг эх нутаг, түүх соёлоороо бахархан өнгөрүүллээ.

6-9-р ангийн сурагчдын дархлааг дэмжих, шимт бодисын ач тусын талаар мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "ҮДИЙН ЦАЙ" хөтөлбөрийг эцэг эх, аж ахуй нэгж, олон нийтийн дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 05 сарын 18-нд "АЯГА СҮҮНИЙ АЧ ТУС" үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

- Сурагчдын "ҮДИЙН ЦАЙ"-нд сүү өгөх
- "АЯГА СҮҮНИЙ АЧ ТУС" сургалт зохион байгуулах
- Эцэг эх, асран хамгаалагчдад уриалга хүргүүлэх ажлыг төлөвлөн зохион байгууллаа.

БУСАД:

"Эрдэм түгээгч сургуулиа
Эзний сэтгэлээр цэвэрлэе" уриан дор сар бүрийн 20-нд 6-9-р ангийн анги хамт олон хуваарийн дагуу их цэвэрлэгээг хийж хэвшлээ. Мөн үйлчилгээний ажилчид "Дотуур байр-ээлтэй орчин" аяны хүрээнд байрны их цэвэрлэгээг сар бүрийн 20-нд хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Үйлчилгээний ажилчид "Дотуур байр-ээлтэй орчин" аяны хүрээнд байрны их цэвэрлэгээг сар бүрийн 20-нд хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.

04.26-ны өдөр сургуулийн аж ахуйн ажил болох ямаа самнах ажлыг хамт олны болон 8,9-р ангийн суралцагчдын хүчээр самнах ажлыг зохион байгууллаа.

2023.05.09-ны өдөр БШУГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт- зөвлөн туслах баг ирж ажиллалаа. Мэргэжлийн хяналтын орчны эрүүл ахуйн хуудсаар:
1. Сургуулийн гадаад дотоод орчны тохижилт- эрүүл ахуй
2.Үдийн хоолны эрүүл ахуй, үйлчилгээний бичиг баримт
3. Дотуур байрны орчны эрүүл ахуй гэсэн үнэлгээ дүгнэлт авлаа.

Дотуур байрны гадаад дотоод орчны эрсдлийн үнэлгээний үр дүнд дотуур байранд "Галын аюулгүй байдал"-ын багаж хэрэгслэл байрлуулах савыг хийж, галын буланг хүний нүдэнд ил харагдауйцаар хийж байршууллаа. Мөн сургууль, дотуур байрны гадаад дотоод орчинд их цэвэрлэгээг хийж эрсдэлтэй газруудыг арилгаж ажилласан.

2022-2023 оны хичээлийн жилд байгууллагад шинээр ажилд орсон ажилчид болон Д.Болормаа багштай 1-р ангийн бяцхан суралцагчид хуваарьт газраа мод суулгаж тарьлаа.

СӨБ-ЫН ЧИГЛЭЛЭЭР:

Цэцэрлэгийн хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулах талаар дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

Нэг. Сургалт үйл ажиллагаа

- Бүлгүүдийн ирцийн тухай бүр нь esis ирц оруулан ажиллаж байна.
- Хувилбарт сургалтын хүүхдүүдэд Хурган дэмжлэг төслийн хаалтын уулзалтыг

зохион байгуулсан бөгөөд хүүхдийн төлөө идэвх зүтгэл, санаачлагатай байсан 26 эцэг эхчүүдэд батламж гардуулж, мөн 3 дахь багцыг өгсөн. Хүүхдийн хийсэн "Дасгал ажил", "Хамтдаа тоглоё", " Монголын уламжлалт наадгай" даалгавруудыг дүгнэж, төслийн талаарх сэтгэгдлийг ярилцсан.

Хоёр. Хүүхдийн хөгжил хамгааллын хүрээнд

- 4 бүлгийн хүүхдүүдийн дунд "Бид дуучин" хамтлаг болон найраглал дууны тэмцээнийг зохион явуулсан бөгөөд нийт 94 хүүхэд хамрагдаж, ахлах бүлгий Гүзээлзгэнэ баг тэргүүлсэн. Наранзаяат дэлгүүр шагналт байрны шагналыг, харин Шидэт Сөд ХХК бүх хүүхдийг витаминжуулж, ивээн тэтгэсэн.
- Хооллох соёл дадал хэвшлийг бүрдүүлэн өдөр бүр хүүхдийг хоолны ширээнд цайны аяга, хоолны аягыг тус тусад нь хийж амны цаасыг зориулалын дагуу хэрэглэж байна.

- Аймшийн төв музей суманд 2 хоног О.Дашбарбарын эдлэж хэрэглэж байсан бэлэг дурсгалын зүйлийг хүүхэд багчуудад танилцуулан үзмэр гарган хүүхдүүдэд танилцуулахад нийт -18+28 хүүхэд үзэж танилцлаа.

“Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлцгээе” зөвлөмжийг 4 бүлгийн дотоод групп эд байршуулсан. Хандалт-73

Гурав.. Мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байдал

- ХАБЭА тухай хуулиар гарын авлага хийж байгууллагын багш ажилчдад өгсөн. Гарын авлага тарааж гарын үсэг зуруулсан.



- Сумын ХАБЭА зөвлөлийн гишүүн Т.Болорчимэгтэй хатран “Хөдөлмөрийн тухай хууль” ХАБЭА тухай хуулиар сургалт зохион байгуулсан.

- Сүхбаатар аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, ХАБЭА ажлын хэсэг ирж сургалт явуулсанд эрхлэгчийн хамт хамрагдсан.

- ЕБС-иас Үндэсний бичгийн өдрийг тохиолдуулан “Хичээнгүй бичиг“-ийн уралдааныг зохион байгуулахад байгууллагын 11 ажилтан хамрагдсан.



- Ажлын байран дээрээ монгол бичгийн сургалтыг ахмад Х.Сарантуяа багшаасаа авахад 14 хүн анхан, дунд шатлалаар суралцаж байна.

- Сайн багшийн-Сайн технологи ур чадварын уралдааны 1-р шатыг цэцэрлэг дээрээ зохион байгуулж, 2-р шатанд Б.Наранчимэг багш шалгарч, аймгийн 1-р бүсэд дүрслэх урлагийн чиглэлээр бэлтгэл бүлэгт “Зургийн үзэсгэлэн” сэдвээр зааж, бүсээсээ 3-т шалгарсан.
- БШУЯ болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсын боловсролын их сургуулийн Нийгмийн ажил арга зүйн тэнхим нь “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” багц үйл ажиллагааны хүрээнд явуулж буй “Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг дэмжих орон нутгийн сургагч багш бэлтгэх” сургалтад заах аргын нэгдлийн ахлагч хамрагдсан. Сургалтын үр дүнд цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг шинэчлэн төлөвлөгөөг боловсруулж, хийсэн ажлаа бүсийн хэмжээнд танилцуулан ажиллаж байна.

Дөрөв. Халдвар хамгаалалт, халдваргүйжүүлэлт

- Хүүхдийн хоол хүнс хадгалах склад агуулахыг цэвэрлэн хөргөгч хөлдөөгч хүнсний тавиурыг содын уусмалтай усаар цэвэрлэн ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.



- Бүлгүүд 7 хоног бүр 0,015% уусмалтай усаар их цэвэрлэгээ хийж хана, тоглоомын тавиур,цонхны тавцанг арчиж хивсээ угааж цэвэрлэдэг.

- Өглөө бүр бүлгийнхээ хүүхдүүдийг хүлээн авч гарыг нь угааж, өдөр бүр амыг зайлж шүдийг нь угаалган хэвшиж байна.

- Анги танхим өрөө тасалгааны агааржуулалтыг 2 цаг тутамд сэлгэх өрөөний агаарын хэмийг 18-20 хэмийн дулаантай тэмдэглэл хөтөлсөн.
- Цэцэрлэг эхлэхийн өмнө,тарсны дараа чийгтэй цэвэрлэгээг 2-3 удаа хийсэн.

- Хүүхдийн тоглоомыг зааврын дагуу өдөр бүр угааж халдваргүйжүүлсэн.
- Ангийн кварцын гэрлийг15-20 минут орой болгон асааж халдваргүйжүүлсэн.
- 7-н хоногийн 5 дахь өдөр бүр бүлгүүд гудсыг салхинд гаргаж халдваргүйжүүлсэн .

- Бүлгийнхээ ор хөнжлийн даавуу нүүр гарын алчуур,унтлаганы хувцасыг угааж индүүдсэн

- Халдварт өвчин гарсантай холбогдуулан байгууллагын өрөө тасалгаа, анги танхимд ариутгал халдаргүйжүүлэлтийг хийсэн.

Тав. Хоол үйлдвэрлэл

- ✓ Хүүхдийн хоолны цэсээ 5 хоногоор гаргаж батлуулан өдөр болгон өдөрлөгөөрөө няраваас хүнсээ авч хүүхдийн хоолоо хийж ажилладаг.
- ✓ Хоолны дээжээ өдөр бүр авч 72 цагийн дараа жижүүр багшийн хяналтан дор устгал хийдэг.
- ✓ Технологийн картаа 1 хүүхдэд ноогдох нормын дагуу цаг тухайд нь хөтөлж хэвшсэн.
- ✓ Хоолны амталгааг жижүүр багшаар хийлгэж тэмдэглэл хөтөлж ажилласан.
- ✓ Тогооч нь цэцэрлэгийн хүүхдийн хоолонд хориглох хүнсийг судалж, самбарт байршуулсан.
- ✓ Эцэг эх асран хамгаалагчдад хүүхдийн хоолны амталгааг явуулсан. 1–р хоол, 2-р хоол, талх нарийн боов, ундаа жүүсээр амталгаа хийлгэсэн. 220 хүнд үйлчилсэн.

- ✓ https://www.esis.edu.mn/teacher хаягаар нэвтрэн орж хоолны цэсийг 7 хоног бүрийг 1 дэх өдөр шивж оруулан баталгаажуулж байна.
- ✓ Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлж буй түүхий эд бүтээгдэхүүнийг гэрээт ААН байгууллагаас татан авалт хийхдээ хугацааг харж хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг буцаан олголт хийж хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Бусад ажил

- Жижүүр гал тогоо болон бүлгүүдийн хог хаягдлыг төвлөрсөн цэгт өдөр бүр шатааж, устгал хийдэг.
- Дунд бүлэг нь эцэг эхийн хүлээн авах өрөөний өнгө үзэмжийг сайжруулан 7м хулдаасыг 84000мянган төгрөгөөр авч тохижуулав.

- 7 хоногийн баасан гараг бүр соёлын төвтэй хамтран спорт заалыг авч, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, бэлтгэл сургуулилтыг хийж хэвшсэн.
- Бүлгийн 27 хүүхдийг хоёр өдөр витаминжуулсан
- ХАБЭА сарын аян -2023” сарын аяны хаалтын үйл ажиллагаа болгож Сумын ХАБЭА зөвлөл болон байгууллагуудын ХАБЭА ажилтан нартай хамтран нөхөрсөг “Гар бөмбөгийн” тэмцээн зохион байгуулж 1,2 р байр шалгаруулан шагнаж урамшуулсан. Нийт 7 баг оролцсон.

- 4 бүлэг эцэг эх, асран хамгаалагчийн хурал хийж холбогдох асуудлуудаа ярилцаж шийдвэрлэн мэдээлэл өгч ажилласан.

- ХАБЭА сарын аяны төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлэн ажиллаж хийсэн ажлын бичмэл тайлан хугацаанд нь Сумын ХАБЭА зөвлөлд хүргүүлсэн.



- Ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулж баталгаажуулдаг.



- Шинээр ажилд орсон ажилтанаар ГЭР – АЖИЛ – ГЭР маршрут гаргуулж авсан.



- ХАБЭА тэмдэг тэмдэглэгээг хийж байршуулсан. Гэрлийн шийдэнд өндөр хүчдэлтэй, халтирахаас болгоомжил, дээрээс юм унах аюултай гэх мэт.

- Шинэ цэцэрлэгийн барилга баригдаж буй ажилд хяналт тавьсан

- Төлөвлөгөөт ДХШ-ын давтан шалгалтыг хийснээр зөрчил 53%-тай арилсан.
- Энэ жилдээ эрүүл жиндээ аяны хүрээнд соёлын төвөөс зохион байгуулж байгаа “Цэнгээт бүжгээр эрүүлжье” ажлын хүрээнд байгууллагын 14 албан хаагч шугаман бүжиг, стандарт бүжиг зэргийг сурч, дасгал хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжиж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн ажилын хүрээнд:

Нийт үзлэг-138
Урьдчилан сэргийлэх-74
Амбулаторт-58
Идэвхитэй хяналт-6
Артерийн гипертензин эрт илрүүлэг-33
Чихрийн шижин эрт илрүүлэг-33
Жирэмсний хяналтанд байгаа-16
Шинээр хамрагдсан-2
Хөхний үзлэг-34
Эсийн шинжилгээ-5
Эмчилсэн эмэгтэйчүүд-0
Эмнэлэгт хэвтсэн-17

Түргэн тусламж-17
Дусал тариа-184
Судас тариа-257
Булчин тариа-36
Арьсан доорх тариа-3
Уян зүү-2
Боолт-6

Сэргээн засах:

- ✓ зөөлөн бариа-2
- ✓ Утлага-4
- ✓ Бумба-3
- ✓ УВЧ-2

Лаборатори:

- ✓ Шээсний шинжилгээ-23
- ✓ В,С вирусын шинжилгээ-83
- ✓ ДОХ,Тэмбүү шинжилгээ-94
- ✓ Сахар-21
- ✓ Covid-19
- ✓ Альбумин-21
- ✓ Билирубин-9
- ✓ Ye мөч-3
- ✓ Сахар-21
- ✓ Алат асат-9
- ✓ Амилаза-15
- ✓ Креатинан-4

Ариутгал

- ✓ Нийт үзлэг багаж-15
- ✓ Хөвөн бөмбөлөг-13
- ✓ Амбу-4
- ✓ Дэлгэш-3
- ✓ Эмэгтэйчүүдийн багаж-22
- ✓ Эмэгтэйчүүдийн толь-5

Дархлаажуулалт

2с- 5 хүүхэд
3с- 3 хүүхэд
4с- 4хүүхэд
5с- 3 хүүхэд
9с-3 хүүхэд
1.2с- 2 хүүхэд
2нас- 3 нийт-23 хүүхдэд хийсэн байна.

Сургалт сурталчилгаа

Эмч ажилчид руу чиглэсэн:

- 2023.04.26 - “ХАБЭрүүл ахуй” аяны хүрээнд “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа” гэж юу вэ?
- “Хачигт халдварын эмчилгээ оношилгоо, шинжилгээ” сэдвүүдээр Нэма С.Зулцэцэг Ариутгагч А.Буд нар сургалтыг 13 ажилчидад зохион байгуулсан.

Иргэд хүүхэд руу чиглэсэн сургалт:

- 2023.05.08 #Хүүхэд_хөгжил_хамгааллыг_дэмжих_жил_2023 хүрээнд

ЭМГ, ЭМТ, "Ортодонт " шүдний эмнэлгийн гурвалсан гэрээний дагуу Нүүр амны их эмч Д.Саруулбуян эмч ЕБС-ийн дотуур байрны 37 хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг хийж

- "Амны хөндийн эрүүл ахуй" сэдвээр эрүүл зан үйлийг төлөвшүүлэх арга, дадлын зөвлөгөө өгч, мэдээлэл хийлээ.✨

-“Шүд эрүүл бол бие эрүүл” уриалгад нэгдэж ЭМТ-өөс дархлаа дэмжин витаминжуулсан.

- 2023.05.01 “Өсвөр үеийн хүүхдийн” эрүүл мэндийг дэмжих 7 хонгийн аян “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд эцэг эх- асран хамгаалагч-уралдааанч хүүхдийн ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ" зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу сумын хамтарсан баг, сургуулийн захиргаа, сумын ХАБЭАЗөвлөл хамтран зохион байгууллаа.
  - СНА-тан "Эцэг эх-асран хамгаалагч-уяачдын эрх үүрэг-уралдааанч хүүхдийн аюулгүй байдал" сэдвээр
  - ЭМНА-тан "Уралдааанч хүүхдэд үзүүлэх анхны тусламж" сэдвээр сургалт зохион байгуулж зөвөлгөөнд оролцсон 70хүүхдийн дархлааг дэмжин багц олголоо.

- “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд соёлын төвөөс зохион байгуулж байгаа “Сумаараа бүжигчин” болцгооё уриан дор “Өглөөний эрүүл мэндийн” дасгалд хамрагдсан иргэдийн дархлааг дэмжин витамжуулсан. Бүжгийн сургалтанд байгууллагаараа хамрагдсан.

- “ЭНЭ ЖИЛДЭЭ -ЭРҮҮЛ ЖИНДЭЭ”-2023

“Өдөр бүр сүү, тараг ууцгаая” 7 хонгийн аяны хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Үүнд:

1. 2023.04.28 Бэлтгэл бүлгийн 22 сурагчдад

- “Сүү тараг уухын ач тус” зөвлөмжийг боловсруулан өгч эрүүл мэндэд хортой, хоргүй зүйлсийг танин мэдэх хөгжөөн баясах үйл ажиллагааг орж дархлаа дэмжих сүү өгч уриалга дэвшүүлсэн.

2. Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад:

- “Сүү тараг уухын ач тус” зөвлөмжийг боловсруулан өгч мэдээлэл өглөө
- “Таргаар дархлаагаа дэмжье” үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн Цахимаар 8 төрлийн мэдээ мэдээлэл түгээсэн хандалтын тоо 130.

Кордиорын сургалтаар иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор

- Гар хөл амны өвчин
  - Давсны хэрэглээг бууруулцгаая сэдвээр 28 иргэнд хийсэн.

Шинэлэг ажил

- Улаанбаатар хот дахь ИОН ЭНЕРЖИ ХХК-ны хөрөнгө оруулалтаар 3500000 төгрөгийн “Нярайн шарлалт хэмжих аппарат” билиметрийг авч нярайн хүүхдэд гэрийн эргэлт хийж шарлалтыг хэмжиж байна.

Бусад:

- 2023.04.18нд ЭМТ-ийн “Ёс зүйн баг”- аас

“Өөрийгөө танин мэдэхүй” дадлага сургалтыг эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилчдад зохион байгуулсан.

Энэхүү сургалтын зорилго: Эмч ажилчид хүн тус бүр баг хамт олноосоо өөрийн давуу болон сул талыг мэдэж авч цаашид өөрийн давуу талаа улам хөгжүүлж, сул тал алдаагаа засан сайжруулан нягт хамт олон болж ажиллахад оршино.

- Гепатитгүй сүхбаатарчууд аяны хүрээнд наран сумын HCV-тэй 9 хүний сорьцыг 2023.04.13 нд АНЭ-т хүргүүлсэн. Хариугаа 04.19 нд авсан үүнээс идэвхжилтэй-1 идэвхжилгүй-8 гарсан байна.Идэвхжилтэй гарсан 1 хүнээс алат,асатын шинжилгээ авч С вирусын эмийн эмчилгээнд хамруулж эмчийн хяналтанд авсан.



.

- Аяны хүрээнд Гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд 83 иргэдийг 2023.04.03-05.11 хүртэл шинжилгээнд хамруулсан. Гепатитын С вирустэй 36 хүнийг С вирусийн ачаалал тоолох шинжилгээнд хамруулж эмчийн хяналтанд авч эмийн эмчилгээнд хамруулсан.
  - 2023.04.25ны өдөр ЭМГ-ын даргаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд заавар зөвлөмж өгч, эмнэлгийн эмч ажидчидад сургалт зохион байгуулсна.

- Байгууллагын тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг шинэчлэн хийж тэмдэглэл хөтөлж байна.

<u>СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:</u>

Соёлын төв 05 дугаар сард:

- Ирсэн бичиг – 5
- Явсан бичиг - 2
    - Хариутай бичиг – 0
    - Хугацаандаа явсан бичиг – 0
    - Хугацаа болоогүй бичиг – 0
    - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. Байгууллагын хүүхдийн өрөөг тохижууллаа.

1.2.Сумын Засаг даргын дэмжлэгээр “Ион энержи” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 4 сая төгрөгийн өртөг бүхий чадлын өсгөгч 1 ширхэг, яригч 2 ширхэг яригчний сэлбэг 6 ширхэгийг хүлээн авлаа.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:
2.1. Төсвийн хүрээнд өр авлага үүсээгүй. Өөрийн үйл ажиллагааны орлого төгрөг орсон.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
3.1. Аймгийн төрийн байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан албан хаагч нарын дунд зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн сургалт”-нд архив, бичиг хэргийн ажилтан оролцож, мэдлэгийн хүрээгээ тэллээ.

3.2. Албан байгууллагаар зөөврийн номын сан ажиллуулж нийт 7 албан байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулсан шинэ номын үзэсгэлэн гаргаж ном унших арга туршлагыг сурталчилах ярилцлага, уулзалтыг зохион байгууллаа.

3.3. Сар бүрийн эхний 7 хоногийн 5 дахь өдөр “Судар эгшиглэн” төслийн оролцогчдын уулзалт ярилцлага хийхээр төлөвлөсөний дагуу 05-р сарын 05-ний өдөр сумын “Хүүхдийн элч” Ж.Хүрэлчимэг, ЕБС-ийн номын санч Д.Чимгээ нартай хамтран зохион байгууллаа. Төсөлд оролцож ном уншиж, тэмдэглэл хөтөлж байгаа 6 том хүн, 37 сурагч хамрагдсан.

3.4. Бага ангийн сурагчдын дунд ”Хамгийн ховор олон номтой хүүхэд” номын үзэсгэлэн гаргах, “Үлгэрийн баатар”-аар зурагт хуудас зурах уралдаануудыг зохион байгууллаа. Үүнд: 1а анги- 20ш ,2а анги -50ш, 3а анги -20ш, 4а анги- 30ш, 5а анги-25ш ховор номуудаар үзэсгэлэн гаргалаа.

3.5. Бага ангийн сурагчдын дунд уншсан номоороо бяцхан ном хийх, дүр бүтээх, бүтээл туурвих, эсээ бичих, том жижиг ном хийх зурагт хуудас гаргах зэрэг ажлуудыг төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгууллаа**.** “Үлгэрийн баатар амилсан нь” дүрийн тоглолт бүтээх уралдаанд 1-р байр 4а анги монгол ардын үлгэр “Өвгөн бар хоёр” 2-р байр 5а анги “Зальт үнэг” 3-р байр 3а анги “Сарны туулай үлгэр” тус тус эзэллээ.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Орон нутгийг судлах танхимын эд өлгийн зүйлсийг бүртгэн баримтжуулах, үнэлгээ тогтоох ажлыг Аймгийн Угсаатны зүйн музейн сан хөмрөгч Ч.Оюунэрдэнэ, Бүртгэл мэдээллийн санч О.Гандиймаа, Арга зүйч Ж.Наранчимэг нартай хамтарч 63 дэсийн 64 үзмэрт хувийн дугаар өгөн. Эдгээр үзмэрийг бүртгэн баримтжуулж, ерөнхий бүртгэлийн дэвтэрийг захиалан авчруулж бүртгэлийг хийж баримтжууллаа. Түүх соёлын дурсгал, Үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журмын дагуу хэлэлцэж дансны үнэлгээг тогтоов. 63 төрлийн эд өлгийн зүйлсийг 9,886,750 төгрөгөөр үнэлэн баримтжууллаа.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. Хөгжмийн дугуйланд 27 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд гитар 5, лимбэ 2, ёочин 3, даралтат хөгжим 12, үкүлэлэ 5 сурагч суралцаж байна. Бүжгийн дугуйланд 21 хүүхэд суралцаж байна. Одоогоор 5-6 бүжгийг өөрсдийн хэмжээнд сайн сураад байна. Дугуйлангийн сурагчдын тайлан тоглолтыг 6-р сарын 01-нд хийхээр төлөвлөн ажиллаж, бэлтгэл хийж байна.



5.2. Бэлтгэл бүлгийн суралцагчидад 3 бүжиг, ахлах бүлгийн суралцагчидад 2 бүжиг сургасан. Дугуйлангийн сурагчидад хамтлаг бүжиг 2, гоцлол бүжиг 2, цөөхүүл бүжиг 1, хосын бүжиг 1-г зааж бүрэн эзэмшүүлээд байна.

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ:

6.1. МУСТА жүжигчин, дуучин Т.Эрдэнэбаярын “Аваа зорино” аялан тоглолтыг 04-р сарын 24-ний өдөр хүлээн авч тоглуулсан. Нийт 126 үзэгч хамрагдсан.

6.2. МУСТА дуучин Х.Ган-Эрдэнийн “Үлэмж торгон аялгуу” тоглолт 05-р сарын 06-ний өдөр болж 263 үзэгч үзэж сонирхлоо.

6.3. МУСТА дуучин П.Ганболдын “Хүн уул” аялан тоглолт 05-р сарын 07-ны өдөр боллоо.

6.4. 4-р сарын 25-30 хооронд мэргэжлийн бүжгийн багшийг урьж авчран цэнгээнт бүжиг, шугаман бүжгийн сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтанд төрийн болон төрийн бус байгууллагын 69 иргэн хамрагдсан. Мөн энэ хугацаанд эрүүл мэндийн өглөөний дасгалыг 06 цагаас зохион байгуулахад давхардсан тоогоор 548 иргэн хамрагдсан.

6.5. Цэцэрлэгийн суралцагчдын дунд “Бид дуучин” тэмцээнийг “Нархан” цэцэрлэгтэй хамтран зохион байгууллаа. Хамрагдсан суралцагч 94, үзэгч 61.

6.6. “Нууц тархи” монголын уран сайхны киног 99 хүүхэд үзсэн.

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

7.1. Ажилчдын монгол бичгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ахмад багш МУБТА Х.Сарантуяагаар өдөр бүрийн 15 цагаас монгол бичгийн хичээл заалгаж байна. Соёлын төвийн 5 ажилтан хамрагдаж байна.

7.2. 04-р сарын 28-30 өдрүүдэд сумын техникийн үзлэг зохион байгуулагдлаа. Нийт 261 хүн үйлчлүүлсэн.

7.3. “Хүүхдээ хамгаалъя” уралдаанч хүүхдийн зөвлөгөөнийг сумын хамтарсан баг, “Гурван хонгор” уяачдын холбоотой хамтран зохион байгуулахад том хүн 41, хүүхэд 59 хамрагдлаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ О.ТУНГАЛАГ